

Б.Жав буюу “АВРАЛ ТҮГЭЭГЧ” эрдэнийн хүндэт тэмдгээр шагнах тухай



БИЛЭГДЭЛ: Дөрвөн зүг найман зохистоо аврал түгээн цацруулна
ОРЦ: мөнгө 999-10гр, 999 алт – 0.6гр, 750 алт – 2гр, циркон шигтгээ 4ш, бадмаараг чулуу 1ш

ЭРДЭНИЙН ХҮНДЭТ ТЭМДГЭЭР ШАГНАХ ЗАРЧИМ

Зорилго: Эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр тасралтгүй ажиллах хугацаандаа эмнэл зүйн ур чадвараа дээшлүүлэн, эмчилгээ оношлогоонд оновчтой арга аргачлал дэвшүүлэн хэрэгжүүлсэн, оюун мэдлэгийн ур чадвараа хөгжүүлэн зэрэг цол ахиулсан, ёс зүйн хувьд доголдолгүй, энэрэнгүй сэтгэл, хамтын ажиллагааг баримталсан эмчийг урамшуулж, эх барихын эмч нарын идэвх санаачлагыг өрнүүлэх зорилготой

“АВРАЛ ТҮГЭЭГЧ” эрдэнийн хүндэт тэмдгээр шагнах болзол буюу шалгуур үзүүлэлт:

1. Ажилласан жил: Эх барих эмэгтэйчүүдийн их эмчийн чиглэлээр тасралтгүй 10-аас дээш жил ажилласан байх;
2. Цол, зэрэг: Тэргүүлэх зэргээс дээш
3. Эрдмийн зэрэг: АУ-ы магистраас дээш эрдмийн зэрэгтэй;
4. Эмнэл зүй: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр тасралтгүй ажилласан сүүлийн 5 жилийн хугацаандаа ахиц дэвшилтэй, оношлогоо, эмчилгээний шинэчилсэн загвар, ашигтай загварын гэрчилгээ, эмчилгээний дэвшилтэт технологи дэвшүүлсэн нэвтрүүлсэн байх;

5. Онол арга зүй: Эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл, илтгэл нийтлүүлж түүнийг олны хүртээл болгосон, мэргэжлийн чиглэлээр ном товхимол, гарын авлага, зөвлөмж хэвлүүлсэн, яриа ярилцлага хийх зэргээр хүн амын нийгэмийн эрүүл мэндийн боловсрол олгох, дээшлүүлэхэд оролцсон байх;
6. Ёс зүй: Эмчийн баримтлах ёс зүйн хэв хэмжээг зөрчилгүй ажилласан байх;
7. Манлайлал: Хамт олноо тэргүүлэх, удирдан чиглүүлэх, хүндлэгдэх, багаар ажиллах чадвартай байх;
8. Гавьяа: Ховор тохиолдох, хүнд нөхцөлөөс эх, хүүхдийн амь насыг эсэн мэнд аварсан байх.

Хугацаа: 3 жил тутамд эрдэнийн хүндэт тэмдэг, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр шагнана.

Зохион байгуулалт: Шагналын болзолыг Нийслэлийн амаржих газрууд, дүүргийн ЭМТ, хөдөө орон нутгийн эмнэлгүүдийн эх барих эмэгтэйчүүдийн эмч нарт мэдэгдэж, материалыг цуглуулах ажлыг Монголын Эх барих Эмэгтэйчүүдийн Эмч нарын Холбоо хариуцна.

Шалгаруулалт: Б.Жав агсны гэр бүлийн гишүүдийн төлөөлөл болон МЭБЭЭНХ-ны ажлын хэсэг ирүүлсэн материалуудыг үндэслэн шалгаруулж, МЭБЭЭНХ-ны удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ.